<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		-		-
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага				
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	21.00	21.00	21.00	21.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00	12.00	12.00
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	4.00	4.00
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00	4.00	4.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	-	-	-	-
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	-	-	-	-
630001	Төрийн өмчит ЕБС				
630002	Хувийн ЕБС				
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	-	-	-	-
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага				
631002	Хувийн өмчит СӨБ байгууллага				
<b>632</b>	<b>МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ</b>	-	-	-	-
632001	Төрийн өмчит МСҮТ				
632002	Хувийн МСҮТ				
<b>64</b>	<b>ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО</b>	-	-	-	-
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо				
640002	Улсын эмнэлгийн амбулатороор эмчлүүлэгсдийн тоо				
640003	Хувийн эмнэлгээр эмчлүүлэгсдийн тоо				
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	-	-	-	-
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)				
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)				
650003	Ажлын албаны албан хаагч (АА)				
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)				
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)				
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)				
650007	Мэргэжлийн боловсролын				

Баяннуур сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)				
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)				
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)				
650010	Гэрээт ажилтан				
650011	Улс төрийн албан хаагч (УТ)				

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Байгууллагын нэр: Баяннуур сумын ЭМТ

Тайлант хугацаа: 2020.12.31

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		18,159,900.00	18,159,900.00	-
21	УРСГАЛ ЗАРДАЛ		16,824,900.00	16,824,900.00	-
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		16,597,324.19	16,597,324.19	-
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил				
210101	Үндсэн цалин				
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл				
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал				
2104	Хангамж, бараа материалын зардал		2,087,600.00	-2,087,600.00	
210401	Бичиг хэрэг		308,000.00	-308,000.00	
210402	Тээвэр, шатахуун		56,600.00	-56,600.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		544,000.00	-544,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		679,000.00	-679,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		500,000.00	-500,000.00	
2105	Нормативт зардал		11,664,224.19	11,664,224.19	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		11,664,224.19	11,664,224.19	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		485,000.00	-485,000.00	
210601	Багаж, техник, хэрэгсэл		485,000.00	-485,000.00	

Баяннуур сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2107	Томилолт, зочны зардал				
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж				
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		2,360,500.00	-2,360,500.00	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		2,360,500.00	-2,360,500.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		227,575.81	-227,575.81	
2132	Бусад урсгал шилжүүлэг		200,000.00	-200,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		200,000.00	-200,000.00	
	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		27,575.81	-27,575.81	
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		27,575.81	-27,575.81	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		1,335,000.00	-1,335,000.00	
	Дотоод эх үүсвэрээр		1,335,000.00	-1,335,000.00	
222001	Тоног төхөөрөмж		1,335,000.00	-1,335,000.00	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		18,159,900.00	18,159,900.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		16,419,900.00	16,419,900.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		16,319,900.00	16,319,900.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		100,000.00	-100,000.00	
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)				
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баяннуур сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга Б.Үүрийнтуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах,үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25–ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Баяннуур сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймгийн Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ**

Баяннуур сумын ЭМТ нь тайлант хугацаанд “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг – Иргэн бүрд жигд хүртээмжтэй хүргэх, Эрүүл мэндийн салбарын төлөвшсөн, тогтвортой боловсон хүчнийг дэмжихэд гол зорилго оршино.” гэсэн зорилго дэвшүүлж үүний хүрээнд доорх зорилтуудыг тавьж ажилласан байна. Үүнд:

1. Хүний нөөц, боловсон хүчний ур чадварыг сайжруулж
2. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг стандарт дүрэм журмын дагуу иргэн бүрд тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлэх
3. Эрт илрүүлэг, урьдчилсан сэргийлэх үзлэгийн чанарыг сайжруулах
4. Нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн төрлийг нэмэгдүүлэх гэх зэрэг зорилтуудыг хэрэгжүүлж ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй, байгууллагын НБББББ-ийг шинэчлэн боловсруулсан байна.

#### **3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ**

Баяннуур сумын ЭМТ-ийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэн боловсруулжээ.

ХАК нь 2020 онд Баяннуур сумын ЭМТ-ийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд баталгаажуулах аудит хийж, нийт 839.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 225.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 345.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 268.8 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн байна.

Зөвлөмжийн хариуг ирүүлж ажиллаагүй байна.

ХАК нь 2019 оны шилэн дансанд хийсэн дотоод аудитаар зөрчил илрээгүй мэдээллийг бүрэн мэдээлсэн гэж дуусгавар болсон тайланд дурдсан байна.

Мөн ХАК нь эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320-д тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 189484.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 3789.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцон төлөвлөж, гүйцэтгэлийн үе шатанд жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт 362474.1 зардлын мянган төгрөгийн зардлаас 2 хувиар буюу 7249.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцон авч үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баяннуур сумын ЭМТ-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8589.8 мянган төгрөгөөр буюу 2.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	20276.6	26474.8	6198.2
Үндсэн хөрөнгө	319976.4	322368.1	2391.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>340253.0</b>	<b>348842.9</b>	<b>8589.9</b>
Өр төлбөр		251.0	251.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	340253.0	348591.9	8338.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>340253.0</b>	<b>348842.9</b>	<b>8589.9</b>

Мөнгөн хөрөнгө данс үлдэгдэлгүй.

Авлага данс эхний болон эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан.

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 26474.8 мянган төгрөг болж 6290.6 мянган төгрөгөөр өссөн нь 78468.9 мянган төгрөгөөр бараа материал нэмэгдүүлсэнтэй холбон үзэж байна.

Тухайн жил төсвийн хөрөнгөөр 62296.2, ЭМГ-аас 16105.4, иргэнээс 67.2 мянган төгрөг буюу нийт 78468.8 мянган төгрөгийн орлогыг материалын орлогод бүртгэн тайлагнажээ.

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 423993.9 мянган төгрөг болж 3209.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 7878.9, хандив тусламжаар 12200.0 мянган төгрөгийн хөрөнгийг нэмэгдүүлж оны эцэст 16869.7 мянган төгрөгийг акталж хасагдсантай холбон үзэж байна.

Тухайн онд элэгдлээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг дахин үнэлж ажиллаагүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдлийг 251.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл нэмэгдэж хасагдсан хөрөнгөгүй байна.

Баяннуур сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт 370905.4 мянган төгрөгийн орлого байгаа нь өмнөх оноос 39144.1 мянган төгрөгөөр буюу 10.5 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь хандив тусламжийн бараа, материалын болон үндсэн хөрөнгө нэмэгдүүлсэн дүнгийн өөрчлөлт байна.

Үр дүнгийн тайлангийн нийт зардал өмнөх оноос 12755.5 мянган төгрөгөөр буюу 3.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалингийн зардал нэмэгдсэнтэй холбон үзэж байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар хуримтлагдсан үр дүн өмнөх оны хуримтлагдсан үр 9063.6 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлт гарснаар тайлагнажээ.

### **3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 280562.4, ЭМДСангаас 29709.9, орон нутгийн төсвөөс 21432.1 буюу нийт 331704.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулж санхүүжүүлэхээр 333848.1 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 280562.4, ЭМДСангаас 27367.3, орон нутгийн төсвөөс 16443.1, нэмэлт санхүүжилтээр 18159.9 мянган төгрөг буюу нийт 342532.7 мянган төгрөгийн санхүүжилт авснаас гүйцэтгэлээр 341813.4 мянган төгрөгийг зарцуулж 719.3 мянган төгрөгийн үлдэгдлийг төсөвт төвлөрүүлэн ажиллажээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 341813.4 мянган төгрөг буюу 99.7 хувийг зарцуулж батлагдсан санхүүжилтийг бүрэн хэмжээнд зарцуулсан байна.

#### **Улсын/орон нутгийн/төсөвт төвлөрүүлэх орлого**

Өөрийн орлогыг төлөвлөөгүй болно.

#### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансны санхүүжилтээр 18159.9 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 18132.3 мянган төгрөгийг зарцуулж 27.6 мянган төгрөгийн үлдэгдлийг төсөвт төвлөрүүлэн ажиллажээ.

### **3.7. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллээс тухай бүр мэдээлэх мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан байна.

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 839.5 мянган төгрөгийн зөрчлөөс 225.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж 345.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 268.8 мянган төгрөгийн зөрчилд өгсөн 4 зөвлөмжийг тус тус биелүүлсэн байна.

Аудитаар өгсөн 268.8 мянган төгрөгийн зөрчлийн 4 зөвлөмжийн хэрэгжилтийг ирүүлж ажиллаагүй байна.

Нийт 839.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 225.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 345.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 268.8 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 3: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт:

/мян/төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	225.0	1	225.0			
Албан шаардлага	1	345.7	1	345.7			
Зөвлөмж	4	268.8			4	268.8	
Нийт дүн	6	839.5	6	839.5			

### 3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4905.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1644.9 мянган төгрөгийн зөрчилд 3 акт тогтоож, 1406.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхаар 1853.4 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгч ажиллалаа.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын 8515.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залруулж ажиллалаа.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 3051.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1644.9 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоон, 1406.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж ажиллалаа. Үүнд:

1. Тус сумын ЭМТ-ийн ажил хавсарсны нэмэгдлийг түүвэрлэн шалгахад ариутгагчийн орон тоог батлаагүй, тушаал шийдвэргүйгээр ажил хавсарсны нэмэгдэлд нийт 1053232 төгрөгийг олгосон зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 5.3-т “батлагдан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан байгууллагын орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг тогтоох”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 6-д “ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтоов.

2. Тус сумын ЭМТ-ийн томилолтын зардлыг анхан шатны баримттай тулган шалгахад анхан шатны баримтын бүрдэлгүй, томилолтын хуудасгүй 112000 төгрөг олгосон зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг

зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д ” Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

3. Тус байгууллагын шатахуун зарцуулалтыг түүвэрлэн шалгахад анхан шатны баримтын бүрдэлгүй, шатахууны даргын цохолтгүй 479715 төгрөгийг шатахууны зардалд зарцуулсан зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д ” Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

4. Тус сумын ЭМТ нь жилийн эцсийн үндсэн хөрөнгө болон бараа материалын тооллого хийсэн гэх боловч санхүүгийн тодруулга тайлангийн үндсэн хөрөнгө, материалын үлдэгдэлтэй тулгахад үндсэн хөрөнгийн дүнг тооллогын дүнг зөрүүтэй тайлагнасан, хүнсний материалын 844560 төгрөгийн, бичиг хэргийн 562300 төгрөгийн үлдэгдэлд тус тус биет тооллого хийгээгүй зөрчлүүд илэрсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2-т Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана.”, 70.2.1-д “1/ үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор/;”, 70.2.2-т “түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/;”, НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.”, 12.3-т “Төрийн өмчийн хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад хуульд заасан хугацаанд болон зайлшгүй шаардлагатай үед хийнэ.”, НБББББ-ийн 72 дугаар зүйлийн 72.4.4-т “эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах”, 72.4.2-т “тоолсон эд хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн жишигтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

#### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Дараагийн аудитаар батлагдсан хүнс, бичиг хэргийн үлдэгдэлд биет тооллого хийснийг, мөн бүтэц орон тоо, цалингийн санг түүвэрлэн авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Тухайн байгууллагын үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого чанаргүй, мөн орон тоог батлуулахгүй тушаал шийдвэргүй ажил хавсарсны нэмэгдэл олгож байгаа нь анхаарал татахуйц байна.

#### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### **1. Зардал данстай холбоотой асуудал**

1.1 Илрүүлэлт: Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж ажиллаагүй, нэхэмжлэх баримт, мөнгөн шилжүүлгээр тулгахад эмийн зарцуулалт 458.5 мянган төгрөгөөр дутуу шилжүүлснээр зөрүүтэй, үлдэгдлийг баталгаажуулж ажиллаагүй, мөн авто машины албан татварын 154.9 мянган төгрөгийн өглөгийг тайланд тусгаагүйг тайланд тусгуулж ажиллалаа.

1.2 Эрсдэл: Төсөв хүрэлцэхгүй өр авлага үүсэх.

1.3 Өгсөн зөвлөмж: НББ-ийн тухай хуулийн 20.2.5, 20.2.6 дахь заалтыг мөрдөж ажиллах.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Улирал бүр харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж ажиллахад хяналт тавьж ажиллана.

##### **2. Зардал данстай холбоотой асуудал**

2.1 Илрүүлэлт: Эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авахдаа тендерт шалгарсан компаниас худалдан авалт хийгээгүй, тендерт шалгараагүй компаниас 172.5 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн зөрчил илэрлээ.

2.2 Эрсдэл: Холбогдох хууль журам зөрчигдөх

2.3 Өгсөн зөвлөмж: Тухайн жилд эмийн тендерт шалгарсан компаниас худалдан авалт хийх, мөн ЭМГ-ийн зөвлөмжийг мөрдөж ажиллах.

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Цаашид тендерт шалгараагүй эм ханган нийлүүлэх компаниас худалдан авалт хийгүй байх талаар арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.

##### **3. Дотоод асуудалтай холбоотой асуудал**

3.1 Илрүүлэлт: Аймгийн ОНӨГ-аас хүргүүлсэн үндсэн хөрөнгөнд дахин үнэлгээ хийх тухай албан тоотын дагуу байгууллагын элэгдлээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг дахин үнэлж ажиллаагүй байна.

3.2 Эрсдэл: Үйл ажиллагаа доголдох

3.3 Өгсөн зөвлөмж: Бусад байгууллагын өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хийж биелэлтийг тооцож ажиллах.

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өмч хамгаалах зөвлөлийг үндсэн хөрөнгөнд дахин үнэлгээ хийхэд арга зүйн зөвлөгөө өгч хяналт тавьж ажиллана.

Дээрх 3 зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 05-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Баяннуур сумын ЭМТ	Аудитын код:
2020			САГ-2021/1/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Булган аймаг дахь Төрийн аудитын газар		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Байгууллагын бүтэц орон тоог батлахдаа ариутгагчийн орон тоог батлаагүй, ариутгагчийн ажил хавсарсны нэмэгдлийг олгохдоо тушаал шийдвэргүйгээр олгосон.	1053.2	Төлбөрийн акт	Дарга, нягтлан бодогч	Б.Үүрийнтуяа, М.Түвшинзаяа
2	Томилолтын зардал олгохдоо удирдамжгүй, томилолтын хуудасгүй томилолтын зардал олгосон.	112.0	Төлбөрийн акт	Дарга, нягтлан бодогч	Б.Үүрийнтуяа, М.Түвшинзаяа
3	Шатахууны зардлыг даргын цохолтгүй, анхан шатны баримт дутуу зарцуулсан.	479.7	Төлбөрийн акт	Дарга, нягтлан бодогч	
4	Жилийн эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого явуулсан гэх боловч үндсэн хөрөнгийн дүнг зөрүүтэй тайлагнасан, хүнсний материалын, бичиг хэргийн тооллого хийгээгүй, тооллогын баримт дутуу байна.	1406.8	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	
5	Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж ажиллаагүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.	613.4	Зөвлөмж хүргүүлэх	Дарга, нягтлан бодогч	
6	Эм эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх тендерт шалгараагүй компаниас эм эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтыг хийсэн.	1240.0	Зөвлөмж хүргүүлэх	Дарга, нягтлан бодогч	
7	Аймгийн ОНӨГ-аас хүргүүлсэн үндсэн хөрөнгөнд дахин үнэлгээ хийх тухай албан тоотын дагуу байгууллагын элэгдлээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг дахин үнэлж ажиллаагүй байна.	0	Зөвлөмж хүргүүлэх	Дарга, нягтлан бодогч	
<b>ДҮН</b>		<b>4905.1</b>			

АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

АУДИТЫН ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

П.МӨНХТУЯА